



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 8/362

Улаанбаатар хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/186 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/186 дугаар захирамжаар шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (М.Дөлгөөн)-д, хоёрдугаар хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нэн яаралтай хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг баталж, "Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ (Э.Онон)-аар гүйцэтгүүлсүгэй.

2. Энэ захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/348 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011045